



МОНГОЛ УЛС
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2017 оны 07 сарын 20 өдөр

Дугаар А/486

Мөрөн

Хөрөнгө зарцуулах тухай


Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29.1.3-ын "а", Төсвийн тухай хуулийн 14.2.5 аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2017 оны 04 дүгээр сарын 28-ны 78 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн Мал хамгаалах сангийн аюулгүйн нөөцөд тусламжаар ирсэн 300 уут буюу 12 тн хүчит тэжээлийг зөөж агуулахад хураах зардал 355.000 /Гурван зуун тавин таван мянган төгрөг/-ийг Мал хамгаалах сангийн бусдаар гүйцэтгүүлэх ажил үйлчилгээний зардлаас зарцуулахыг нягтлан бодогч /Н.Аззаяа/-д зөвшөөрсүгэй.

2. Зөөж хураасан тэжээлийн хадгалалт, хамгаалалтанд хяналт тавьж ажиллахыг Мал хамгаалах сангийн нягтлан бодогч /Н.Аззаяа/-д үүрэг болгосугай.

3. Энэхүү захирамжийн биелэлтэнд хяналт тавьж ажиллахыг аймгийн ЗДТГ-ын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч Э.Аззаяа, Хүнс, хөдөө аж ахуйн газрын дарга Г.Баттулга нарт үүрэг болгосугай.

ДАРГА



Л.ГАНБОЛД